

**"АГААРЫН ХӨЛГИЙН БҮХЭЭГТ ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ТОДОРХОЙ
БУСАД ҮЙЛДЛИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН НЭМЭЛТ ПРОТОКОЛ"-ЫГ СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТАЛААРХ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ,
ДҮГНЭЛТ**

2023 оны 06 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Уг хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, уг хэлээгүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж тус конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

"Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг зөвшилцөх, хэлэлцүүлэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, уг хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХ-АМГАЛАН

TUS3761 9023051390 9087184

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

“АГААРЫН ХӨЛГИЙН БҮХЭЭГТ ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ТОДОРХОЙ БУСАД ҮЙЛДЛИЙН ТУХАЙ КОНВЕНЦЫН НЭМЭЛТ ПРОТОКОЛ”-ЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Канад Улсын Монреал хотноо 2014 онд баталсан “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай конвенцын нэмэлт протокол”-ыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг